

Дүрвэгсдийн Уртасгасан Процедур

Та яагаад энэ товхимолыг хүлээж авав?

Та Нидерландын Вант улсад орогнол хүсэж өргөдөл өгсөн. Immigratie- en Naturalisatiedienst (IND) – Дүрвэгсэд ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага таныг дүрвэгсдийн зөвшөөрлийн бичиг авах болзлуудыг хангаж буй эсэхийг шалгаж байна. Ерөнхий Дүрвэгсдийн Процедур нь найман хоног үргэлжилдэг. Таны өргөдлийг судлахад IND – д илүү хугацаа хэрэгтэй байна. Тиймээс IND үргэлжлүүлэн таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийг Дүрвэгсдийн Уртасгасан Процедурээр шийдвэрлэнэ. Та энэ товхимолоос Дүрвэгсдийн Уртасгасан Процедур хэрхэн үргэлжилдэг тухай уншина.

Дүрвэгсдийн процедур

Та аль хэдийн IND–д өөрийгөө хэн болох, ирэхдээ туулсан замынхаа тухай ярилцлага өгсөн байгаа. Түүнчлэн та эх орноо орхин гарч дүрвэх болсон шалтгааныхаа тухай хоёр дахь ярилцлагаа ч өгсөн байх. Хэрвээ IND–д танаас асуух асуултууд байхгүй бол та Дүрвэгсдийн Уртасгасан Процедурийн үеэр IND–гийн кантоор явах шаардлагагүй. Хэрвээ та хоёр дахь ярилцлагандаа ороогүй эсвэл IND танаас нэмэлт асуултууд асуух бол таныг нэмэлт ярилцлаганд урина. Дүрвэгсдийн Уртасгасан Процедурийн үед ч та өмгөөлөгчөөс үнэгүй тусламж авна. Та дүрвэгсдийн өргөдлийн хариугаа Нидерландын Вант улсад хүлээж болно. Энэ хугацаандаа та СОА–гийн дүрвэгсдийн байранд байрлах болно. Та Дүрвэгсдийн Уртасгасан Процедурт хамрагдаж байна уу? Энэ үед та өөр Дүрвэгсдийн өөр байр луу нүүх боломжтой.

Урьдчилсан шийдвэр

Та зургаан сарын дотор IND – гээс судалгааны үр дүнг гаргасан захидал хүлээн авна. Энд хоёр боломж бий:

1. Та дүрвэгсдийн оршин суух зөвшөөрөл авах болзлыг хангаж байна. Танд (өмгөөлөгчөөр тань дамжуулж) IND захидал (=beschikking) (шийдвэр) өгнө. Энэ захидалд таны дүрвэгсдийн өргөдлийн хариуд зөвшөөрсөн хариу өгсөн тухай бичигдсэн байна. Та (түр хугацаанд) Нидерландын Вант улсад үлдэж болно. Өмгөөлөгч танд энэ нь ямар үр дагавар авчрах тухай тайлбарлаж өгнө.
2. IND таныг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах болзлыг хангахгүй байна гэсэн шийдвэр гаргах боломжтой. Энэ үед IND таны орогнол хүссэн өргөдөлд татгалзах төлөвлөгөөтэй байна гэж бичсэн захидал өгнө. Энэ нь захидлыг урьдчилсан шийдвэр гэж нэрлэдэг. Энэ захидалд яагаад татгалзсан хариу өгөх болсон шалтгаанаа дурдаж танд мөн энэ хариу ямар үр дагавар авчирч болохыг заасан байна. Өмгөөлөгч таньтай уг захидлын талаар хэлэлцэнэ.

Үзэл бодол

Хэрвээ IND таны орогнол хүссэн өргөдөлд татгалзах төлөвлөгөөтэй байгаа бол, та өмгөөлөгчтөйгөө урьдчилсан шийдвэрийн талаар ярилц. Таны өмгөөлөгч IND-д бичгээр үзэл бодлоо илэрхийлнэ. Үүнийг үзэл бодлоо илэрхийлж хариу бичих гэж хэлдэг. Энэ захидалдаа IND-гийн гаргасан урьдчилсан шийдвэрийг албан ёсоор эсэргүүцээд та мөн шалтгаанаа дурдах ёстой.

Шийдвэр

IND таны илгээсэн үзэл бодлыг уншсаны дараа урьдчилан гаргасан шийдвэрээ өөрчлөх эсэхийг шийддэг. Эндээс гарсан шийдвэр дахиад л таны дүрвэгсдийн процедур хэрхэн явагдахыг тодорхойлно. IND гаргасан шийдвэрээ захиагаар таны өмгөөлөгчид мэдэгдэнэ. Таны өмгөөлөгч танд энэ шийдвэр ямар үр дагавартай болохыг тайлбарлаж өгнө. Энд хоёр боломж бий:

1. IND таны илгээсэн үзэл бодлыг уншаад дараа нь таныг дүрвэгсдийн оршин суух зөвшөөрлийг авах болзлыг хангаж байна гэж үзэх. IND танд захидал буюу шийдвэр (=beschikking) (өмгөөлөгчөөр тань дамжуулан) өгнө. Энэ захидалд таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийн хариуг зөвшөөрсөн гэж бичсэн байна. Та (түр хугацаанд) Нидерландын Вант улсад оршин сууж болно. Таны өмгөөлөгч танд энэ нь ямар өөр үр дагавар авчирч байгааг тайлбарлаж өгнө.
2. IND гаргасан шийдвэрээ үлдээж таныг дүрвэгсдийн орогнол хүссэн оршин суух зөвшөөрөл авах болзлыг хангахгүй байна хэмээн шийдвэрлэх. Танд (өмгөөлөгчөөр тань дамжуулан) IND таны орогнол хүссэн өргөдлийн хариуд татгалсан гэж бичсэн (=шийдвэр) өгнө. Энэ шийдвэрийн хажуугаар тусад нь хариунаас гарах үр дагаварыг зааж, энэ шийдвэрийн эсрэг авч болох арга хэмжээ мөн буцах боломжуудыг тайлбарласан мэдээлэл өгнө. Татгалзсан хариундаа татгалсан шалтгааныг дурдаж танд ямар үр дагавар авчирхыг бичсэн байна. Таны өмгөөлөгч гарсан шийдвэрийн тухай таньтай хэлэлцэнэ.

Дүрвэгсдийн процедурын дараа

Хэрвээ IND таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлийн хариуд зөвшөөрвөл та (түр хугацаанд) Нидерландын Вант улсад оршин сууж болно. Та оршин суух зөвшөөрлийн бичиг хүлээн авна, та ажил хийж болно, мөн гэр бүлийнхээ гишүүдийг ч авчруулж болно.

Үүнээс гадна COA орон сууц олоход зуучилж өгдөг. Тогтмол оршин суух байрны холбогдолтой чухал мэдээллийг COA-тай ярилцаж тодорхойлж өгнө. Таны энэ мэдээлэл нь Нидерландын Вант улсын аль нэгэн хотын захиргаанд холбогддог. Үргэлжлүүлэн хотын захиргаа танд тохиромжтой байр хайж өгдөг. Танд ганцхан удаа л орон сууц санал болгодог. Та үүнийг хүлээн авах ёстой. Та байраа олтоого COA-гын хүлээн авах төвд амьдарч болно. Таныг зөвшөөрсөн хариу авсны дараа IND таны эрхийн тухай, үлдсэн гэр бүлийн гишүүдээ авчрах ба таны үүргүүдийн тухай мэдээлэл өгдөг. VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтнууд таныг Нидерландын Вант улсын нийгэмд дасан зохицоход болон таны гэр бүлээ эргэн нэгтгэх процедурт тусална. Тэд мөн танд төрөл бүрийн байгууллагуудтай холбогдоход, тухайлбал орон сууц олоход, сургууль, ажилд ороход тусалдаг.

Хэрвээ IND таны дүрвэгсдийн өргөдөлд татгалзвал, та өмгөөлөгчтөйгөө хэлэлцээд Нидерландын Вант улсын шүүгчид энэ шийдвэрийн эсрэг давж заалдаж болно. Энэ нь та шүүгчид IND-гийн гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаагаар албан ёсоор илэрхийлж байна гэсэн үг юм. Шүүгч үргэлжлүүлэн IND Нидерландын Вант улсын хуулийн дагуу таны дүрвэгсдийн өргөдлийг шийдсэн эсэхийг судална. Та мөн шүүгчээс давж заалдах процедурын үеэр Нидерландын Вант улсад үлдээж өгөхийг хүсэж болно. Үүнд таны өмгөөлөгч тусалж чадна.

Хэрвээ IND таны дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдөлд татгалзсан бол, таныг ихэнхдээ өөр дүрвэгсдийн төв рүү аваачдаг. Танд тэнд Нидерландын Вант улсыг орхин гарах бэлтгэлээ хангана. IND-гийн шийдвэрт таныг ямар хугацаанд Нидерландын Вант улсыг орхин гарах ёстойг заасан байгаа. Ихэнхдээ энэ нь 28 хоног байдаг. Энэ хугацаа өнгөрмөгц таны орон байраар хангагдах эрх дуусдаг. Түүнчлэн та дүрвэгсдийн төвд байж болохгүй болно.

Та эх орондоо буцах хариуцлагыг өөрөө хүлээнэ. Хэрвээ та заасан хугацаанд өөрөө санаачлагаараа буцахгүй бол таныг албадан эх оронлуу тань буцаана.



Хэрвээ та эх орондоо санаачлагаараа буцах хүсэлтэй бол, Internationale Organisatie voor Migratie (IOM)-Олон Улсын Дүрвэгсдийн Төлөөх Байгууллагатай холбоо барьж болно. IOM таныг буцахад тусалж бодитой мэдээллээр хангана. Ихэнх дүрвэгсдийн төвүүд дээр IOM-той цаг тохирч уулзаж болдог.



Dienst Terugkeer en Vertrek
Ministerie van Veiligheid en Justitie

Dienst Terugkeer en Vertrek (DT&V) - Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) нь Нидерландын Вант улсын Хууль Зүй ба Батлан Хамгаалах Яамны харьяа байгууллага юм. Хэрвээ чи татгалзсан хариу авсан бол, чамайг эх орондоо буцах ажлаа зохион байгуулахад DT&V байгууллагын ажилтан тусалдаг.

Дүрвэгсдийн процедурынхаа дараа та ДүрвэгсдийнАжил (VluchtelingenWerk) байгууллагаас тусламж ба мэдээлэл авч болно.

Хувь хүний мэдээллийн боловсруулалт

Хувь хүний мэдээлэл бол таны талаарх бүх төрлийн мэдээлэл юм. Энэ товхимолын доор бидэнтэй хамтран ажиллаж буй байгууллагуудын нэрсүүд байгаа. Эдгээр байгууллагууд таны цагаачлалын өргөдөл, мэдэгдэл эсвэл хүсэлтийг боловсруулах явцдаа таны хувийн мэдээллийг ашигладаг. Танаас тэд таны мэдээллийг асуугаад хэрвээ шаардлагатай бол бусад байгууллагууд, хүмүүсээс таны талаархи мэдээллийн талаар лавладаг. Эдгээр байгууллагууд таны өгөгдлийг ашиглаад, хадгалж, хуулийн дагуу шаардлагатай бол бусад байгууллагуудад мэдээллийг дамжуулдаг. Хувь хүний нууцлалын тухай хууль тогтоомжинд таны өгөгдлийг боловсруулдаг байгууллагуудын дагах ёстой үүргүүдийг заасан байдаг. Жишээлбэл, тэд таны өгөгдлийг анхааралтай, аюулгүйгээр боловсруулах ёстой. Хувь хүний нууцлалын тухай хуулинд мөн таны эрхийн талаар заасан байдаг, тухайлбал:

- Байгууллагуудаас өөрийн мэдээллийн талаар асууж мэдэх;
- Байгууллагууд таны өгөгдлөөр юу хийдэг, яагаад таны өгөгдлийг хуримтлуулж байгаа гэдгийг мэдэх;
- Цаашлаад ямар байгууллагуудад таны мэдээллийг дамжуулж өгч байгааг мэдэх эрхтэй.

Та өөрийн хувийн мэдээллийн боловсруулалт болон өөрийн эрхийн талаар илүү ихийг мэдэхийг хүсч байна уу? Тэгвэл тухайн байгууллагуудын вэбсайтуудыг судлана уу. Энэ товхимлын доод хэсэгт та тэдгээр байгууллагуудын вэб хаягуудыг олж болно.

Түгээмэл асуултууд

IND-д өгөх ярилцлагандаа очоогүй бол юу болох вэ?

Та IND-тэй уулзах цагтаа очиж чадахгүй байж болох боломжтой. Танд хүндэтгэн үзэх чухал шалтгаан байгаа бол түүнийгээ та өмгөөлөгчөөрөө дамжуулан IND-д мэдэгдээрэй. Хэрвээ IND таны шалтгааныг хүлээн зөвшөөрвөл танд шинээр цаг авч өгдөг. Хэрвээ та ямар нэгэн шалтгаангүйгээр IND -гийн цагт ирээгүй бол таны дүрвэгсдийн өргөдөлд нөлөө үзүүлэх болно.

IND-гийн судалгаа хир удаан үргэлжилдэг вэ?

Таныг Дүрвэгсдийн орогнол хүссэн өргөдлөө өгсний дараа IND зургаан сарын дотор шийдвэрээ гаргах ёстой. Заримдаа IND нэмэлт судалгаа хийхээр энэ хугацааг сунгаж болдог. Хэрвээ IND зургаан сарын дотор шийдэж чадахгүй бол, танд IND-гээс мэдээ ирнэ. Хэрвээ та IND-д дүрвэгсдийн өргөдлөө өгснөөс хойш зургаан сараас илүү хугацаа өнгөрч, танд IND шийдвэрээ явуулаагүй ба IND-гээс мэдээ ирээгүй бол яах вэ? Та тэгвэл IND-ээс бичгээр хоёр долоо хоногийн дотор таны дүрвэгсдийн процедурын асуудлыг шийдэхийг шаардаж болно. Өмгөөлөгч тань үүнд тусалж чадна. Таны өмгөөлөгч шүүгчид хандаснаар IND-ээс шийдвэр гаргаагүй удсан хоног бүрээр торгуулийн мөнгө төлүүлэх боломжтой.

Энэ товхимолыг уншсаны дараа танд асуух зүйл байна уу?

Танд асуултууд байгаа бол өөрийнхөө өмгөөлөгч юмуу COA, IND юмуу VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтнуудын нэгнээс нь асуугаарай.

Та гомдолтой байна уу?

Бүх дүрвэгсдийн процедуртай холбоотой ажилладаг байгууллагууд мэргэжлийн түвшинд, хянамгай ажиллах гэж хичээж байдаг. Хэрвээ та үнэхээр ямар нэгэн байгууллага танд муугаар хандсан гэж үзэж байгаа бол, гомдол мэдүүлж болно. Таны өмгөөлөгч юмуу VluchtelingenWerk- (ДүрвэгсдийнАжил) байгууллагын ажилтан танд туслах болно.

Энэ нийтлэлийг хамтран гаргасан:

Дүрвэгсдийг Хүлээн Авдаг Төв Байгууллага (COA) | www.coa.nl

Эх оронд нь буцаах болон буцах байгууллага (DT&V) | www.dienstterugkeerenvertrek.nl

Дүрвэгсэд – ба Иргэншлийн Асуудлыг Хариуцсан Байгууллага (IND) | www.ind.nl

Хууль эрх зүйн Зөвлөгөө өгөх газар | www.rvr.org
Нидерландын ДүрвэгчдийнАжил байгууллага | www.vluchtelingenwerk.nl

Даалгавраар бичигдэв.

Батлан Хамгаалах ба Хууль Зүйн Яам, Дүрвэгсдийн асуудал хариуцсан захиргааны www.rijksoverheid.nl

Энэ нийтлэлийн агуулгад зохиогчийн эрхийг түгээх боломжгүй. Хэрвээ орчуулгад утга санааны зөрөө гарвал Нидерланд хэл дээрхи нийтлэлийг дагана.